

Боловсруулах технологи



Хүний тодорхой зорилготой,
идэвхтэйгээр хийж гүйцэтгэж буй
үйлийг хөдөлмөр гэнэ.

Бидний эргэн тойронд харагдаж,
бидний эдэлж,
эзэмшиж байгаа бүхэн
хүний хөдөлмөрөөр бүтжээ.



**Техник гэдэг нь хүний
хөдөлмөрийг хөнгөвчлөх,
хурдасгах зориулалттай
төхөөрөмж, эсвэл ажлын
арга барилыг хэлнэ.**



МОД БОЛОВСРУУЛАЛТ



**Монгол оронд ямар
ямар мод ургадаг вэ?**

**Нарс, хуш, шинэс, гацуур,
жодоо, хус, улиас,
улиангар, хайлаас, тоорой**



Мод хүний амьдралд ямар ач холбогдолтой вэ?

- Дунд зэргийн мод өдөрт 3 хүний амьсгалах хүчилтөрөгчийг ялгаруулна.
- Хотын ногоон цэцэрлэгт тарьсан мод агаарыг цэвэрлэнэ.
- Тоос шороог өөртөө шингээнэ.
- Мод дуу шуугианыг сааруулна.
- Түлшинд хэрэглэгдэнэ.
- Төрөл бүрийн модон эдлэл хийнэ.




**Манай орны газар нутгийн хэдэн
хувийг ой мод эзэлдэг вэ?**

**Монгол орны газар нутгийн
8.1%-ийг ой мод эзэлдэг
байна.**



Монгол орны ойн бүтэц



Зуны улиралд:

- 1 хайлаас мод 23 кг
- 1 бургас мод 38 кг
- 1 улиас мод 34 кг
- 1 голт бор мод 1,6 кг
- 1 шар хуайс мод 0,2 кг тоос шороог тус тус навчныхаа гадаргуу дээр буулган авдаг байна.



**Модон эдлэл хийхийн
тулд модоо хэрхэн
боловсруулдаг вэ?...**



ЗҮСМЭЛ МОДОН МАТЕРИАЛ



Өнөөдрийн хичээлээр...

- **Мэдлэг:**

Зүсмэл модон материалын тухай анхны мэдэгдэхүүнтэй болж, материалын төрөл ангилал, зориулалтыг мэдэх,

- **Чадвар:**

Зүсмэл модон материалыг хийж буй эдлэлдээ тохируулан зөв сонгож чаддаг болох,

- **Төлөвшил, хандлага:**

Ой модыг хайрлан хамгаалах төлөвшлийг олж авах,



**-Зүсмэл модон материал гэж
юуг хэлэх вэ?**

**-Зүсмэл модон материалын
ангилал**

**-Зүсмэл модон материалын
гологдол**



Эдлэл хийхийн тулд модыг
төрөл бүрийн хэлбэр,
хэмжээтэй боловсруулсныг
зүсмэл модон материал
ГЭНЭ.



ЗҮСМЭЛ МОДОН МАТЕРИАЛ

- БАНЗ
- ДҮНЗЭЛСЭН МОД
- ШУГАМЛАСАН МОД



БАНЗ

Төрөл бүрийн эдлэл
хийхэд зориулж

2,5 см, 3 см, 5 см зузаантайгаар
бэлтгэсэн зүсмэл модон
материал

...хашаа, шал...



БАНЗ

- ЗАХ БАНЗ
 - ЗАХЛААГҮЙ БАНЗ
 - ЗАХАЛСАН БАНЗ
- Хацар, мөр, тайрсан тал



ДҮНЗЭЛСЭН МОД

100мм-ээс дээш
хэмжээтэй / зузаантай /
боловсруулсан
зүсмэл модон материал

...төмөр замын дэр мод, байшингийн яс мод ...



ДҮНЗЭЛСЭН МОД

- 2 талт
- 3 талт
- 4 талт



ШУГАМЛАСАН МОД

Овор хэмжээ багатай эдлэл
хийхэд зориулж нарийхнаар
зүссэн модон материал

...цонхны хүрээ, жааз, сандлын хөл...



ШУГАМЛАСАН МОД

- Хөндлөн огтлол нь тэгш
өнцөгт
- Хөндлөн огтлол нь квадрат



**Модон материалын
гологдол нь боловсруулах
үеийн болон ургалтын гэж
хоёр янз байна.**



**Зүсмэл модон
материалд хатаалт,
хадгалалтын явцаас
шалтгаалан
сэнсрэлт, хагаралт, цууралт
зэрэг боловсруулалтын
гологдлууд гардаг.**



Ургалтын гэмтэлд
яр, ан цав, мушгиралт,
өмхрөлт, хорхой идэлт
багтана.



Өнөөдрийн хичээлээр:

- Зүсмэл модон материалын тухай,
 - Зүсмэл модон материалын ангиллын тухай,
 - Зүсмэл материалын гологдлын тухай
- МЭДДЭГ БОЛЛОО.**

Төрөл бүрийн эдлэлд тохируулан
зүсмэл модон материалаа сонгож
ЧАДДАГ БОЛЛОО.



Гэрийн даалгаварт:

Тракторын загварын бүтцийг
тодорхойлж, тэдгээрийг хийх модон
материалд сонголт хийж бичиж ирэх

